

**Өлгийсумын ЗДТГ-ын 04-р сарын 27-с эхлэн 7 хоногт
хийсэн ажлын мэдээлэл**

2018.05.03

- “Соёлтой хот” аяны хүрээнд хот дотор хар замын тэмдэглэгээ хийх, замын тэмдэг байрлуулах ажлын төсөв тооцоо гаргав.
- Аймгийн Прокурорын газарт Цагдаагийн газраас манайд шилжүүлсэн согтууруулах ундаа болон тамхины төрөлд шалгалт хийлгэв.
- 5-р бүрэн дунд сургуулийн орчинд үйл ажиллагаа явуулж буй дэлгүүр, гуанзанд улсын байцаагчтай хамт хяналт шалгалт явуулж, үүрэг даалгавар өгсөн болно.
- Ховд голын гүүрний амны хайрга, шороо борлуулдаг самсовал машинуудыг Замын цагдаагийн тасагтай хамтран журамлах үйл ажиллагаа явуулав.
- Нэгдсэн эмнэлгийн хашааны дотор байрлах Нийтийн бие засах газрын асуудлыг Нэгдсэн эмнэлгийн дарга Т.Серикжантай ярьж, байнгын ажилгаатай болгохоор болсон. Засварыг нэгдсэн эмнэлэг хариуцаж хийхээр болов.
- “Соёлтой хот” аяны хүрээнд 6 чиглэлийн эзэнгүй хог цэвэрлүүлэх кадастрын зураг гаргаж ажилтан албан хаагчдын тоогоор хуваарилалт хийж албан байгууллага ААНэгжүүд хүргүүлсэн.
- Багуудын ИНХурлыг хийж 2019 онд ОНХСангаар хийх ажлын санал асуулга явуулав.
- Баг тус бүрээс нэг “Жишиг гудамж”-ийг БЗДарга нартай хамтарч сонгож кадастрын зурагт буулгах ажлыг хийв. Үүнд: /2,3,4,5,6,8,10,11,12,13-р багуудын /
- Цэргийн албанд татагдсан залуучуудыг эмнэлгийн үзлэгт бүрэн хамруулав.
- Засаг даргатай хамт шинээр хайргын карьерийн талбайг судалж, АМХГазрын байцаагч нартай хамт хуучин карьерүүдийг хаах, нөхөн сэргээлт хийлгэх шаардлага тавьж хамтарч ажиллав.
- Гудамж зам талбайн цэвэрлэгээ хийж 6 тн хог ачиж хогийн цэгт хүргэв.
- Гудамж зам талбайг шөнийн гэрэлтүүлгээр хангаж, урсгал засваруудыг хийж байна
- СӨХ-ны хогийг ачиж орон сууц орчмын цэвэрлэгээ хийж байна
- Багуудын нутаг дэвсгэрт нохой буудах ажлыг багийн засаг дарга нартай хамт захиалгаар явж 20 ш нохой буудаж зайлуулав.
- Ногоон бүсийн модон хашааны болон цэцгийн мандлуудын нурж унасан хэсгийг засварлаж шороог янзалж цэцэг тарихад бэлдэж байна.
- Хогийн цэгийг шинэ газарт нүүлгэн хог асгах нөхцөлөөр хангаж ажиллаж байна.
- Ногоон бүс болон цэнгэлдэх хүрээлэнд усалгааны ажилд зориулан худаг ухаж ашиглалтанд өгсөн усалгааг эхэлж хийж байна

Өлгий сумын ЗДТГ